



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Боловсрол-Өргөө нэгдсэн дотуур байр 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/99/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Миндүг Аудит ХХК
Гүйцэтгэх захирал С.Энхтөр
Утас: 95957791
Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо
Утас: 90098901
Цахим хаяг: soo@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Алдааны залруулга	15
5.2 Зөвлөмж	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 101

танай _____-ны № _____-т

**СҮХБААТАР АЙМГИЙН БОЛОВСРОЛ
ӨРГӨӨ НЭГДСЭН ДОТУУР БАЙРНЫ
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.БЯМБАЖАВ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн "Боловсрол өргөө нэгдсэн дотуур байр"-ны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн "Боловсрол өргөө нэгдсэн дотуур байр"-ны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

Дээд шатны төсвийн захирагчаас батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 1 хөтөлбөр, 4 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилт 83.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аудитын гол асуудал

Үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 102,737.8 мянган төгрөг буюу 22 хувиар өссөн нь 32,400.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материал үнэ төлбөргүй хүлээн авсан, Засгийн газрын 107 дугаар тогтоол, БШУ-ны сайдын А/122 тоот тушаалаар цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой санхүүжилт нэмэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үйл

D:/Bichig hereg/2023/A4 toot

ажиллагааны тайлан, бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>36,579,867.00</u>	<u>64,936,636.07</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	32,145,535.07
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	32,145,535.07
3121	Төгрөг	-	32,145,535.07
31211	Төрийн сангийн харилцах	-	32,145,535.07
33	АВЛАГА	-	99,364.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	99,364.00
35	БАРАА МАТЕРИАЛ	36,579,867.00	32,691,737.00
351	Түүхий эд материал	773,400.00	370,890.00
35130	Эм боох материал	773,400.00	370,890.00
354	Хангамжийн материал	35,806,467.00	32,320,847.00
35410	Бичиг хэргийн материал	170,000.00	170,000.00
35420	Аж ахуйн материал	1,296,600.00	1,017,600.00
35450	Барилгын засварын материал	400,000.00	215,000.00
35460	Хүнсний материал	1,725,700.00	268,080.00
35470	Бусад хангамжийн материал	32,214,167.00	30,650,167.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,044,039,329.17</u>	<u>1,999,438,443.37</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,044,039,329.17	1,999,438,443.37
392	Биет хөрөнгө	1,986,279,329.17	1,940,636,776.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,047,730,823.01	2,047,730,823.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	(122,135,728.68)	(164,744,208.24)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	86,323,160.17	102,364,660.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	(60,967,914.41)	(70,167,924.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	92,007,999.00	92,007,999.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(57,079,009.92)	(66,954,573.00)
39217	Ном	400,000.00	400,000.00
393	Биет бус хөрөнгө	57,760,000.00	58,801,666.63
39301	Програм хангамж	-	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(458,333.37)
39303	Бусад биет бус хөрөнгө	58,420,000.00	58,420,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(660,000.00)	(660,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,080,619,196.17</u>	<u>2,064,375,079.44</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>8,472,030.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	8,472,030.00
413	Өглөг	-	8,472,030.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	6,075,030.00
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	-	1,500,000.00
4136	Бусад өглөг	-	897,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	897,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,080,619,196.17</u>	<u>2,055,903,049.44</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,080,619,196.17	2,055,903,049.44

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	86,640,000.00	86,640,000.00
51101	Өмч: - төрийн	86,640,000.00	86,640,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,993,979,196.17	1,969,263,049.44
51210	Өмнөх үеийн үр дүн	2,038,048,964.80	6,119,867.00
51220	Тайлант үеийн үр дүн	(44,069,768.63)	1,963,143,182.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,080,619,196.17</u>	<u>2,064,375,079.44</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	480,350,300.00	2,570,947,467.17
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	383,415,400.00	2,020,260,029.17
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,020,260,029.17
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	2,005,260,029.17
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	2,005,260,029.17
120009	Бусад орлого	-	15,000,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	383,415,400.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	383,415,400.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	96,934,900.00	550,687,438.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,752,050.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,752,050.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	96,934,900.00	133,634,788.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	96,934,900.00	133,634,788.00
1330	Төсвийн захирагчдаас	-	414,300,600.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	414,300,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	524,420,068.63	607,804,284.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	524,420,068.63	607,804,284.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	518,319,473.42	603,177,547.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,982,207.31	259,693,474.45
210101	Үндсэн цалин	169,991,021.62	190,631,070.91
210102	Нэмэгдэл	38,714,987.25	44,513,502.39
210104	Урамшуулал	14,276,198.44	24,548,901.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,462,135.67	31,100,878.52
210201	Тэтгэврийн даатгал	20,363,537.13	21,251,608.52
210202	Тэтгэмжийн даатгал	2,377,938.18	2,498,425.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,779,490.63	1,998,740.27
210204	Ажилгүйдлийн даатгал	539,786.28	478,372.56
210205	Эрүүл мэндийн даатгал	4,401,383.45	4,873,732.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,782,182.81	83,299,700.00
210301	Гэрэл, цахилгаан	12,316,003.75	13,517,069.20
210302	Түлш, халаалт	53,208,121.06	54,267,030.80
210303	Цэвэр, бохир ус	15,258,058.00	15,515,600.00

2104	Хангамж, бараа материалын зардал	6,257,175.00	6,344,290.00
210401	Бичиг хэрэг	1,328,900.00	1,053,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,150,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,389,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,029,275.00	31,490.00
210408	Бараа материал акталсны зардал	-	5,259,200.00
2105	Нормативт зардал	101,510,984.00	132,382,280.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,009,299.00	517,580.00
210502	Хоол, хүнс	99,363,685.00	131,864,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,138,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,676,950.00	16,191,490.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,500.00	-
210604	Урсгал засвар	15,673,450.00	16,191,490.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,005,900.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,005,900.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,641,938.63	74,165,434.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	12,023,049.10
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,641,938.63	62,142,385.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,100,595.21	4,626,736.86
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,100,595.21	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,100,595.21	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	4,626,736.86
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,626,736.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(44,069,768.63)	1,963,143,182.44
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(44,069,768.63)	1,963,143,182.44

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	480,350,300.00	565,687,438.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	383,415,400.00	15,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	15,000,000.00
120009	Бусад орлого	-	15,000,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	383,415,400.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	383,415,400.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	96,934,900.00	550,687,438.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,752,050.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,752,050.00
131106	Төсвийн урамшуулал		

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	96,934,900.00	133,634,788.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	96,934,900.00	133,634,788.00
1330	Төсвийн захирагчдаас	-	414,300,600.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	414,300,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	480,350,300.00	523,500,402.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	480,350,300.00	523,500,402.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	474,249,704.79	518,873,666.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,982,207.31	259,693,474.45
210101	Үндсэн цалин	169,991,021.62	190,631,070.91
210102	Нэмэгдэл	38,714,987.25	44,513,502.39
210104	Урамшуулал	14,276,198.44	24,548,901.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,462,135.67	31,200,242.52
210201	Тэтгэврийн даатгал	20,363,537.13	21,350,972.52
210202	Тэтгэмжийн даатгал	2,377,938.18	2,498,425.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,779,490.63	1,998,740.27
210204	Ажилгүйдлийн даатгал	539,786.28	478,372.56
210205	Эрүүл мэндийн даатгал	4,401,383.45	4,873,732.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,782,182.81	83,299,700.00
210301	Гэрэл, цахилгаан	12,316,003.75	13,517,069.20
210302	Түлш, халаалт	53,208,121.06	54,267,030.80
210303	Цэвэр, бохир ус	15,258,058.00	15,515,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,217,414.00	31,490.00
210401	Бичиг хэрэг	702,050.00	-
210402	Тээвэр, шатахуун	1,150,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,103,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,902,364.00	31,490.00
2105	Нормативт зардал	103,804,475.00	128,970,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	940,000.00	-
210502	Хоол, хүнс	101,516,475.00	128,970,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,348,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,698,940.00	5,236,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,754,490.00	236,500.00
210604	Урсгал засвар	15,944,450.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,807,900.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,807,900.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,494,450.00	10,441,559.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,441,559.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,494,450.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,100,595.21	4,626,736.86
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	4,626,736.86
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,626,736.86
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,100,595.21	-
213502	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	6,100,595.21	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	42,187,035.07
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	10,041,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	10,041,500.00

2200	Дотоод эх үүсвэрээр	-	10,041,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	10,041,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(10,041,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	32,145,535.07
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	32,145,535.07

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	86,640,000.00	0.00	2,130,975,523.79	2,217,615,523.79
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-28,880,000.00	-28,880,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	86,640,000.00	0.00	2,102,095,523.79	2,188,735,523.79
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	-64,046,558.99	-64,046,558.99
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-44,069,768.63	-44,069,768.63
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	86,640,000.00	0.00	1,993,979,196.17	2,080,619,196.17
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	86,640,000.00	0.00	1,993,979,196.17	2,080,619,196.17
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-2,080,770,178.17	-2,080,770,178.17
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	86,640,000.00	0.00	-86,790,982.00	-150,982.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,056,054,031.44	2,056,054,031.44
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	86,640,000.00	0.00	1,969,263,049.44	2,055,903,049.44

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	565,904,050.00	530,335,673.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	565,904,050.00	530,335,673.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	565,904,050.00	530,335,673.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290,100,900.00	530,335,673.83
210101	Үндсэн цалин	257,867,900.00	190,631,070.91
210102	Нэмэгдэл	16,523,900.00	44,513,502.39
210104	Урамшуулал	15,709,100.00	24,548,901.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,780,700.00	31,200,242.52
210201	Тэтгэврийн даатгал	25,712,900.00	21,350,972.52

210202	Тэтгэмжийн даатгал	3,025,000.00	2,498,425.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,420,100.00	1,998,740.27
210204	Ажилгүйдлийн даатгал	602,100.00	478,372.56
210205	Эрүүл мэндийн даатгал	6,020,600.00	4,873,732.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,299,700.00	83,299,700.00
210301	Гэрэл, цахилгаан	12,000,000.00	13,517,069.20
210302	Түлш, халаалт	55,784,100.00	54,267,030.80
210303	Цэвэр, бохир ус	15,515,600.00	15,515,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,490.00	31,490.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31,490.00	31,490.00
2105	Нормативт зардал	128,970,700.00	128,970,700.00
210502	Хоол, хүнс	128,970,700.00	128,970,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00	14,999,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	9,999,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,720,560.00	12,023,049.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,720,560.00	12,023,049.10
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	547,935,388.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	547,935,388.00
122005	Орон нутгийн төсвөөс	-	547,935,388.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	32,145,535.07

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Боловсрол-Өргөө дотуур байр нь Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг орон байраар хангах үйл ажиллагаа явуулдаг БШУ-ны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг нь эрдэм боловсролтой, эрүүл бие бялдартай, зөв харилцааг эрхэмлэсэн иргэн болж төлөвших зорилготой.

“Эрдэмд чи боол мэт зүтгэвэл Эрдэм чамайг хаан мэт хүндэлнэ” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2022 оны 3 сарын 9-ний өдрийн 107 тоот тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”
- Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан тоот “Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах”
- БШУ-ны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/122 тоот тушаал “Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай”
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө дунд байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах/ шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Боловсрол-Өргөө нэгдсэн дотуур байрны 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа улсын секторын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Боловсрол-Өргөө нэгдсэн дотуур байрны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,244.1 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

Мөнгөн хөрөнгө	-	32,145.50	32,145.50
Авлага	-	99.40	99.40
Бараа материал	36,579.90	32,691.70	-3,888.20
Үндсэн хөрөнгө	2,044,039.30	1,999,438.40	-44,600.90
Нийт хөрөнгө	2,080,619.20	2,064,375.10	-16,244.10
Өр төлбөр	-	8,472.00	8,472.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,080,619.20	2,055,903.00	-24,716.20
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,080,619.20	2,064,375.10	-16,244.10

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,999,438.4 мянган төгрөг болж, 44,600.9 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар буурсан, бараа материалын үлдэгдэл 32,691.7 мянган төгрөг болж 3,888.2 мянган төгрөг буюу 11.9 хувиар буурсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,183,508.0 мянган төгрөг буюу 454.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. Тухайн өсөлт нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэн авч нэгтгэхтэй тохируулах бичилтүүд хийгдсэн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 83,384.2 мянган төгрөг буюу 15.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нэмэгдэл цалин, хоол хүнсний зардал байгаа нь хоолны нормативт зардал нэмэгдсэн болон бараа үйлчилгээний үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Цалингийн зардал 36,711.3 мянган төгрөгөөр, хүүхдийн хоол хүнсний зардал 32,501.0 мянган төгрөгөөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 432,052.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 133,851.4 мянган төгрөг нийт зарлагыг 565,904.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 565,904.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 414,300.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 133,634.8 мянган төгрөгийн нийт 547,935.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Нэмэлтээр 15,000,0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлого 2,752.1 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Тайлант хугацаанд 1 хөтөлбөр 6 зориулалт, 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 95 хувийн гүйцэтгэлтэй байна.

Д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80112	Нийтлэг үйлчилгээ	45,551.70	45,335.10	216.60	90%

2	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	88,299.70	88,275.80	23.9	100%
3	81806	Дотуур байрны үйлчилгээ	267,170.70	264,940.10	2,230.60	100%
4	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	147,129.90	115,920.80	31,209.10	79%
5	81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах	2,752.10	2,332.00	420.1	100%
6	83602	ЗГ болон засаг даргын нөөц хөрөнгөөс хуваарилсан	15,000.00	13,531.90	1,468.10	100%
			565,904.10	530,335.70	35,568.40	95%

Батлагдсан төсөв гүйцэтгэлийн зөрүү 35,568.4 мянган төгрөг байна. Үүний 32,145.5 мянган төгрөг нь зарцуулагдаагүй төсвийн үлдэгдэл бол 3,206.2 мянган төгрөгийн зардалд тохируулга хийж, 216.6 мянган төгрөгийн санхүүжилт дутуу орсон байна.

Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан

Зориулалт, арга хэмжээний код	ЭЗ Ангилал 2015	Үзүүлэлт	Тохируулга
80111	210604	Урсгал засвар	23.90
81806	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,295.17
81844	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	420.10
83602	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,467.06
			3,206.23

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Боловсрол-Өргөө нэгдсэн дотуур байрны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах

асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Миндүг Аудит” ХХК-ны /МНБ, аудитор/ С.Энхтөр, аудиторын туслах М.Уламбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Б.Бүзмаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, тус газрын Дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Боловсрол-Өргөө нэгдсэн дотуур байрны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов..

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.0 хувиар буюу 5,499.8 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,849.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд хэтэрсэн зардал байхгүй байна. Нийт батлагдсан төсвөөс 32,145.5 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан нь дансны үлдэгдлийн баталгаагаар нотлогдож байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилот болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Боловсрол-Өргөө нэгдсэн дотуур байр нь 2022 онд нийт 143 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулахаас 127 мэдээллийг хугацаандаа мэдээллэсэн, 16 мэдээллийг хугацаа хоцроосон зөрчилтэй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Боловсрол-өргөө нэгдсэн дотуур байранд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 61,600.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 48,200.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, 13,400.0 мянган төгрөгийн албан шаардлага өгснөөс хэрэгжилт 100 хувьтай биелсэн байна.

Элэгдлээр өртгөө нөхсөн 56 нэр төрлийн 48,200.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох эрх бүхий байгууллагуудаас зөвшөөрөл авч данснаас хасах зөвлөмж өгсөн. Акталж, данснаас хасах саналыг аймгийн ОНӨГ-т хүргүүлж шийдвэрийн дагуу зөрчлийг арилгаж, зөвлөмжийг биелүүлсэн байна.

Хүснэгт 3. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	13,400.0	1	13,400.0	100
Зөвлөмж	2	48,200.0	2	48,200.0	100
Нийт дүн	3	61,600.0	3	61,600.0	100

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар аливаа акт, албан шаардлага хүргүүлэх асуудлууд илрээгүй бөгөөд НДШ-ийн зардлыг илүү тайлагнаж төлснийг тайланд залруулга хийх, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж өглөө.

